

## ҮНЭЛЭМЖИЙН ТУХАЙ ФИЛОСОФИ ОНОЛ ҮҮССЭН ТУХАЙД

*Т.Дорждагва (Доктор Ph.D, профессор)*

*Б.Гантөмөр (Доктор Ph.D)*

*Философи, шашин судлалын тэнхим, МУИС*

*А.Одгэрэл (Ахлах багш)*

*Утга зохиол, урлаг судлалын тэнхим, МУИС*

**Түлхүүр үг:** *Үнэлэмж, үнэлэмжийн онол, үнэлэмжийн философи, аксиологи*

**Товч утга:** *Энэхүү өгүүллийг зохиогчид үнэлэмжийн тухай философи онол үүсэн бүрэлдсэн асуудлыг авч үзэхдээ тодорхой тодорхой сэтгэгчдийн үзэл баримтлал, хэлсэн санааг иш үндэс болгожээ. Тэгэхдээ үнэлэмжийн тухай философи онол XIX-XX зууны заагт боловсрогдсон нь байгалийн шинжлэл, ялангуяа физикт гарсан агуу их нээлтүүдтэй цаг хугацааны хувьд давхцаж байна гээд энд үндсэндээ герман сэтгэгчид гол гавъяаг байгуулжээ гэж дүгнэсэн байна.*

1990-ээд оноос өмнө манай оронд ганц марксист-ленинист гэх үзэл суртал дагнан ноёрхож байсны улмаас философи сэтгэлгээний хөгжлийн түүхэн дэх зарим ололтыг үнэгүйдүүлэн “шүүмжилж”, орчин үеийн зарим ололтыг хүртэж чадахгүй өнгөрч байлаа. Харин дэлхийн социалист систем нуран унаж, улс орон ардчилал, зах зээлийн харилцааны замыг сонгосноор уламжлалт болон уламжлалт бус философийн онол, үзэл баримтлал, чиглэл, урсгалуудыг аль бололцоот хэмжээгээр үзэж судлах боломж нээгдсэн юм. Үнэлэмжийн тухай асуудалтай манайхан харьцангуй хожуу учирсан хэдий ч уг асуудлыг сургалтын төлөвлөгөөнд тусган оруулж, хичээлийн хөтөлбөр боловсруулан их, дээд сургуулиудад зааж эхэлсэн төдийгүй, улмаар хэд хэдэн хүн энэ чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалсан байх юм. Энэ тухай бид өөрсдийн бүтээлдээ нэгэнт дурдаж байсан билээ.<sup>1</sup> Тэрчлэн бид цөөн тооны илтгэл, өгүүлэл хэлэлцүүлж, хэвлүүлж байсан<sup>2</sup> бөгөөд үүний өмнө

“Үнэлэмжийн философи үүсэх урьдчилсан нөхцлийн тухайд”<sup>3</sup> гэдэг нэртэй өгүүллийг хэвлүүлсэн юм. Харин энэ удаад түүний үргэлжлэл болгон энэхүү өгүүллийг уншигч танаа өргөн толилууля.

XIX зууны 60-аад онд германы философич Г.Лотце<sup>4</sup>-гийн “Практик философийн үндэслэлүүд” хэмээх шастир хэвлэгдэн нийгэд хүрсэнээр юмслаг хэлбэртэй, объектив бодит ахуйгаас зарчмын хувьд ялгаатай үнэлэмжийн үзэгдлийн өвөрмөц чанарыг илрүүлэх эхлэл тавигдаж, бодит байдал нэг төрөл болох тухай соён гэгээрүүлэгчдийн нэг талыг баримталсан онтологи төсөөллийг даван туулсан гэдэг. Тэрээр “Микрокосм” гэдэг гол бүтээлийнхээ гурван ботид үндсэндээ уг ойлголтын талаар ярьж, энд оюуны амьдралын “дотоод үнэлэмж”-ийн тухай, “мэдрэх сэтгэгдлийн үнэлэмжүүд”-ийн тухай, “хүний хөгжлийн үнэлэмж” болон

зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд (CD). 2015.10.16.; Т.Дорждагва. Монгол хүний тухай үнэлэмжийн асуудалд // “Монголоо монголоор нь удирдахуй” шилдэг илтгэлийн эмхэтгэл. УБ.: Шинэ удирдлагын академи, 2014.

<sup>3</sup> Т.Дорждагва, Б.Гантөмөр. Үнэлэмжийн философи үүсэх урьдчилсан нөхцлийн тухай // Philosophy, Religious Studies. Official Journal of the National University of Mongolia. Vol. 18.

<sup>4</sup> Германы философич Рудольф Герман Лотце (1817-1881) Лейпцигийн их сургуулийн анагаах ухааны факультетэд 1834 онд элсэн орж, суралцаж байх хугацаандаа философийг шаргуу сонирхон оролджээ. Тэрээр 1838 онд сургуулиа төгсөхдөө философийн докторын зэрэг, дараа нь анагаах ухааны докторын зэрэгтэй болж, 1839 оноос эхлэн сургуулиа даа философи болон анагаах ухааны хичээлүүд зааж байсан байна.

<sup>1</sup> Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. Дөтгөөр хэвлэл – УБ.: БИТПРЕСС, 2013. – 73-74 дэх талд үзнэ үү.

<sup>2</sup> Т.Дорждагва. Үнэлэмжийн тухай ойлголтыг тодорхойлох асуудалд // МУИС, НШУС-ийн эрдэм шинжилгээний бичиг (Философи, шашин судлалын салбар 244 (27) III). -УБ.:МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2005. -33-42 дахь талд; Үнэлэмж // Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. Дөтгөөр хэвлэл – УБ.: БИТПРЕСС, 2013. – 73-74 дэх талд; Т.Дорждагва. “Үнэлэмж” хэмээх ойлголтонд холбогдох зарим эргэцүүлэл//“Философийн сургалт, судалгаа: өчигдөр, өнөөдөр” МУИС-ийн Философийн салбарын 50 жилийн ойд

“түүхийн үнэлэмжүүд”-ийн тухай авч үзжээ.

Хүн ертөнцтэй холбогдох сэтгэл хөдлөлийн холбоонд ач холбогдол өгөн сэтгэхүйн танин мэдэх үйл ажиллагааны хүрээг хумьж Г.Лотце романтик ухамсрын зарчим, херменевтик болон “амьдралын философи”-ийн анхны алхамд тулгуурласан нь илэрхий байдаг. Харин хожим М.Хайдеггер (1889-1976) германы философид үнэлэмжийн онолыг буй болгоход зориулан уншсан лекцэн дээрээ “Лотце үнэлэмжийн асуудлыг бүрэн авч үзсэнгүй”, яагаад гэвэл тэр “системээс зүрхшээхийн хамт түүнд эрмэлзсэн” гэж ёжлосон байна. Гэхдээ л Г.Лотце “бидний дур зоргоос огт хамаарахгүйгээр бидний мэдрэхүйд ханддаг бөгөөд бидний мэдрэхүйгээр эрэмблэл нь тогтоогддог” буян, сайхан, шудрага болон ахуйн бусад илрэлүүдийг үнэлэмжид оруулж үзсэн нь философийн түүхэн дэх нэгэн их үйлийг эхлүүлсэн нь ойлгомжтой юм.

Соёлд үнэлэмжийн ухамсрын эзлэх байр суурийг тогтооход Ф.Ницше (1844-1900) -гийн философи шийдвэрлэх ач холбогдолтой болсон гэж үздэг байна. Ницше онтологийг аксиологид уусгахдаа объектив бодит байдлыг биш, үнэндээ үнэлэмжийг өөрөө ахуй гэж тайлбарласаны хувьд метафизик дахь үнэлэмжийн тухай үзэл санаа шийдвэртэйгээр ноёлох болж ирлээ хэмээн М.Хайдеггер түүнийг үнэлжээ. Аксиологийг буй болгоход Ф.Ницшегийн гүйцэтгэсэн үүргийг мөн В.Виндельбанд (1848-1915) цохон тэмдэглэсэн байдаг ба үнэлэмжийн философийн онолын үндсийг боловсруулахад Заратустра “хөрсийг нь сийрэгжүүлж өгсөн” гэж соёлын түүхч А.Штерн (1907-1942) бас дурссан байна.

Энд Заратустрагийн хандлагыг аваад үзье. Тэрээр: “Хүмүүс дээр ирж уулзахад тэд хүнд юу сайн, юу муу гэдгийг бүгдээрээ бүр эртнээс мэддэг юм шиг байдгаас нь өөрсдийн хуучин санаа бодолтойгоо байгааг би олж хардаг. Гэтэл юу сайн, эсвэл муу гэдгийг хэн ч мэддэггүй. Сайн, муугийн тухай бичсэн христч ойлголтын

хуучин үндсийг хөнөөх нь яагаад хэрэгтэй вэ? Яагаад гэвэл тэр үнэнийг нээдэггүй, харин нуудаг. “Чи хулгай хийх ёсгүй! Чи аллага үйлдэх ёсгүй!” гэсэн үгнүүд хэзээ ч ариун дагшин ... гэж нэрлэгдээгүй. Гэхдээ би танаас асууя. Тийм ариун дагшин үгс оршин байснаараа аль зуунд, хаана хамгийн лут дээрэмчид, алуурчдыг мөрдөж болох байлаа? Амьдралд өөрт нь дээрэм, аллага нэлэнхүйдээ байгаагүй гэж үү дээ? Харин ч тийм үгнүүд ариун дагшинд тооцогдож, үнэн өөрөө үхэлд хүртлээ алагдаж байгаагүй гэж үү?”<sup>5</sup> гэснийг эргэн санахад илүүдэхгүй юм.

Ф.Ницше 1887 онд бичсэн “Ёс суртахууны генеалогид” гэдэг шастиртаа “сайн” ба “муу”-г “газар дэлхийд мянга мянган жилээр үхлийн тулаан хийсэн ... эсрэг тэсрэг үнэлэмжүүд” гэж авч үзэн эдгээр үнэлэмжүүдийн үнэлэмжийг хэрэг болгон авч үзэх нь хойшлуулашгүй зорилт болох тухай асуудлыг дэвшүүлсэн байна. Мөн “Философичийн ирээдүйн зорилт бол бүх шинжлэх ухааны баримтын үндсэн дээр үнэлэмжийн асуудлыг шийдвэрлэх хийгээд үнэлэмжүүдийн зэрэглэлийн хүснэгтийг тодорхойлоход оршино”<sup>6</sup> гэсэн ажээ. Харин XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн европын философийн хөгжлийн бодит үйл явц эдгээр зорилтыг хэрэгжүүлсэн байна. Нэгэн жишээ гэвэл прусс-америкийн философич, хавсрага сэтгэл судлалын мэргэжилтэн Г.Мюнстерберг (1863-1916) XX зууны эхээр “Үнэлэмжийн философи” гэдэг номондоо “Ертөнцийг үзэхүйн үндсэн зарчмууд” гэсэн нэртэй хүснэгт оруулсан нь аксиологи сэтгэлгээний түүхэнд анх удаа ертөнцийг үнэлэмжийн үүднээс ухварласан, хүний ертөнцийг үзэхүйг бүрэн хамрах бүтцийн зүй тогтлыг илэрхийлсэн хүснэгт гэж үнэлэгдсэн ажээ. Тухайлбал, феноменологийн салбарын нэрт төлөөлөгч Э.Хуссерль (1859-1938) үнэлэмжийн ертөнцийг шинжлэхдээ өөр хандлага баримталж байсан ч Г.Мюнстербергийн үзэл баримтлалыг өндөр үнэлж байсан гэдэг. Түүнийг сонирхон үзье<sup>7</sup>.

<sup>5</sup> М.С.Каган. Философская теория ценности. Санкт-Петербург, ТОО ТК “Петрополис”, 1997. – 14-15 дахь талд үзнэ үү.

<sup>6</sup> Мөн тэнд, 15 дахь талд

<sup>7</sup> Мөн тэнд

	Логик үнэлэмжүүд	Эстетик үнэлэмжүүд	Этик үнэлэмжүүд	Метафизик үнэлэмжүүд
Амьдралын үнэлэмжүүд	Бэлэн ахуйн үнэлэмжүүд (шууд хүртэх юмс)	Нэгдлийн үнэлэмжүүд (баяр бахдалын мэдрэмжийн юмс)	Хөгжлийн үнэлэмжүүд (дээшлэх юмс)	Бурхан тэнгэрлэг үнэлэмжүүд (итгэл бишрэлийн юмс)
Гадаад ертөнцийн	Юмс	Зохирол	Өсөлт	Бүтээхүй
Ойрын хүрээллийн	Оршихуй	Хайр	Дэвшил	Нээгдэл
Дотоод ертөнцийн	Үнэлэхүй	Аз жаргал	Өөрийн хөгжил	Аврал
Соёлын үнэлэмжүүд	Үнэлэмжүүд (танин мэдэхүйн юмс)	Үнэлэмжүүд (зугаа цэнгэлийн юмс)	Үнэлэмжүүд (хүлээн зөвшөөрөх юмс)	Үнэлэмжүүд (итгэл үнэмшлийн юмс)
Гадаад ертөнцийн	Байгаль	Дүрслэх урлаг	Аж ахуй	Орчлон
Ойрын хүрээллийн	Түүх	Яруу найраг	Эрх	Хүн төрөлхтөн
Дотоод ертөнцийн	Оюун ухаан	Хөгжим	Зан байдал	Дээд “Би”

Энэхүү хүснэгт нь тогтолцооны чанартай байгааг бид харж байна. Тухайн үедээ судлаачид түүнийг тийм үнэлж ирсэн бололтой. Харин энд соёлын аксиосферт хөндлөнгийн юм уу гэхээр зарим үзэгдэл ажиглагдаж байгааг тэмдэглэмээр санагдаж байсан юм. Гэвч аливаа өргөн цартай асуудлыг хатуу тогтолцоод оруулан хайрцаглана гэдэг амаргүй зүйл болохыг төсөөлж байгаа тул их эрдэмтний энэхүү оролдлогийг уншигч таны мэргэн шүүлтэнд үлдээлээ.

XX зууны эхээр философи сэтгэлгээнд түрүүхэндээ ноёрхон гялалзаж байсан эпистемологи сэдвийг шахан аксиологи асуудалд философичдын анхаарал улам бүр ихэд татагдах болсон байна. Английн философич В.Урбан 1909 онд “Орчин үеийн философид хүндийн төв танин мэдэхүйн асуудлаас үнэлэмжийн асуудалд шилжив, танин мэдэхүйн асуудал өөрөө заримдаа хэсэгчлэн, заримдаа бүхлээрээ үнэлэмжийн асуудалд уусах болов ... үнэлэмжийн асуудал өнөөдөр шиг ингэж анхаарлын төвд байх цаг хугацааг философи сэтгэлгээний түүхээс олоход бэрх юм, яагаад гэвэл интеллектуализм волонтаризмаар солигдолт буюу хүн төрөлхтөний өмнө тулгамдсан үнэлэмжийн суурь өөрчлөлт боллоо”<sup>8</sup> гэх мэтээр дүгнэсэн байна. Тэрээр бас хожим нь 1929 онд “Бодит байдалд үнэлэмж харилцах харилцаа нь манай цаг үеийн түлхүүр асуудал ... онолын философийн үндсэн асуудал ... энэ баталгааг замхруулах

хүмүүс цөөхөн”<sup>9</sup> гэж нотложээ.

Энэ асуудал АНУ-ыг ч байлдан дагуулжээ. 1913 онд Америкийн философийн холбооны гүйцэтгэх хороо нэг хурал дээрээ үнэлэмжийн асуудлыг тусгайлан хэлэлцүүлсэн байна. 1968 онд Парист хэвлүүлэн гаргасан “Орчин үеийн үзэл санааны панорам” гэдэг дээж бичгийн нэг өмнөх үгэндээ судлаач Г.Пикон тэр цаг үеийн шинж чанарыг илэрхийлж: “XIX зууны сүүлээс улам илүү хурдтай гарч, өнөөдөр бидэнд жинхэнэ мутаци болсон амьдрал, сэтгэлгээний нөхцлийн өөрчлөлтүүд бидний оршихуйг тодорхойлж, хүн төрөлхтөний алив алхамыг шүүж байдаг үндсэн зарчмуудыг асуудал болгон зайлшгүй тавих ёстой байсан. Бидний гуманизм, этик, иргэншил, соёл гэж нэрлэдэг, өөрөөр хэлбэл бидний удирдлага болгодог, бид тэр үндсэн дээр зан үйлээ үнэлэдэг тэр үнэлэмжүүд бас л эргэлзээнд орсон байлаа”<sup>10</sup> гэжээ.

Оюуны энэхүү нөхцөл байдалд философи хариу өгөхгүй байж чадаагүй байна. Философийн хүн судлалыг үндэслэгч М.Шелер (1874-1928) шашны үнэлэмжүүдийг дээд хэлбэр нь гэж хүлээн зөвшөөрөөд хүний оюуны бүхий л амьдралыг үнэндээ үнэлэмжид оруулсан байна. Энэ үеийн философийн өөр нэгэн гарамгай төлөөлөгч, кантч

<sup>8</sup> Urban W.M. Valuation, its Nature and Laws, being an Introduction to the General Theory of Value. – L., 1909.

<sup>9</sup> Urban W.M. The Intelligible World. – L. – N. - Y., 1929. [2 ed. - 1977]. (В.Урбаны хэлсэн үгүүдийг М.С.Каган. Философская теория ценности. Санкт-Петербург, ТОО ТК “Петрополис”, 1997. номны 16 дахь талаас орчуулан орууллаа)

<sup>10</sup> Мөн тэнд

шинэ үзлийн Бадены сургуулийн тэргүүн В.Виндельбанд XIX зууны Германы оюуны амьдралд философийн гүйцэтгэсэн үүргийн судалгаанд зориулсан ажилдаа (1909 онд) "... одоо үед философи нь ерөөсөө нийтлэг учир холбогдол бүхий үнэлэмжийн тухай сургаал болсон байна, яагаад гэвэл бүх үнэлэмжийг дахин үнэлэх гэсэн Ф.Ницшегийн уриа манай өнөөдрийн лоозон болсон ба өнөөдөр бид философиос хүлээж байгаа юм бол солигдон өөрчлөгддөг, хүмүүсийн түр зуурын ашиг сонирхлын дээр мандах, оюуны дээд бодит байдлаар үндэслэгдсэн мөнхийн үнэлэмжийн тухай эргэцүүлэл юм"<sup>11</sup> гэж нотолжээ.

Тэрээр үүнийгээ тайлбарлахдаа: "Өнгөрсөн зууны эхэн үеийн интеллектуаль чин эрмэлзлэл гандаж тэдний байрыг хариуцлагатай дур зорго эзлэв ... Амьдралын хуучин хэлбэр задарч шинэ үнэлэмжийн сэдлүүд буй болсон нь эрэл хайгуул болон тэнсэж мэдэхүйг хөөрлийн төлөв байдалд, өөрийн илэрхийллийг шаардах эрчимтэй исэлтэнд хүргэсэн ба урьдчилан харж Гегель: "Олон түмэн ургашаа хөдөлсөн, хэрэв түүхэн хөдөлгөөн урьд өмнө нь нийгмийн дээд нимгэн давхраанд голчлон тэдний дээгүүр тоглолт хийж байсан бол одоо олон түмэн зөвхөн улс төрд төдийгүй, оюуны амьдралын бүхий л салбарт, эдийн засагт ч адил яг тийм хэмжээгээр өөрийнхөө эрхийг тунхаглан мэдэгдэж байна ... Манай амьдрал ийм маягаар огт өөр шинж чанартай боллоо ... Энэ нь амьдралыг ойлгох үнэлэмжийн ойлголтонд бүр шинэ агшин болон гүн гүнзгийгээр хэрэгжих өөрчлөлтүүдийг оруулж байна ..." үр дүнд нь "зөвхөн бүхий л цаг үеийн турш бүтээж байдаг бөгөөд бүтээсэн соёл болон түүхээ, чухамдаа бие хүний амьдрал болох тэр дээд юмаа алдах ... том аюул үүсэн буй болж байна" гэж хэлсэн нь зөв байжээ гэсэн байна.

Энэ бол цаг хугацааны л тулгарсан хэрэгцээ байсан бөгөөд амьдралын эрэлт шаардлагад хариулт өгөхөд томилогдсон үнэлэмжийн философийг төрүүлсэн үйл явдал байжээ. Саяхан л бид 1990 оны ардчилсан хувьсгалаас өмнө хувийн өмч, өрнөдийн нийгмийн байгуулал, олон намын тогтолцоог улангасан шүүмжилж байснаа орхиж, нийгмийн амьдралын

бүхий л хүрээнд гүн гүнзгий өөрчлөлт хийж, үнэлэмжийн огт өөр ертөнцөд амьдран аж төрж байгаа нь дээрхийн нэгэн адил түүх бус уу. Гэхдээ Гегелээс ишлэсэн Виндельбандын дээрх санааг бид ухаалгаар хүлээн авч аливаа үйл ажиллагаандаа, ялангуяа улс төрийн зорилгоор харгалзан үзэж байх шаардлагатай байж болно.

Энэ мэтээр аксиологийн асуудал хүн төрөлхтөний оюун сэтгэлгээний түүхэнд хүчтэй түрэн орж ирсэн нь соёлыг "хэрэгжсэн үнэлэмжүүдийн ертөнц"<sup>12</sup> гэж ойлгоход хүргэсэн бөгөөд ингэж л соёлын түүх төрсөн байх нь. Цаашилбал эдгээр урьдчилсан нөхцлүүдээс О.Шпенглер (1880-1936) болон түүнийг залгамжлагчдын "локаль иргэншил"-ийн онол үүдэж, байгалийн ба хүмүүнлэгийн гэх эрдэм ухааны хоёр бүлгийг судлагдахуун болон аргаар нь ялгахад үнэлэмжийн харилцааны өвөрмөц чанар мөн л инээмсэглэн угтаад авчээ. Ийм ялгааны үндэслэл хэдийгээр Э.Хуссерль (1859-1938), В.Дильтей (1833-1911), В.Виндельбанд (1848-1915), Г.Риккерт (1863-1936) нарт өөр өөрийн онцлогтой ч түүний онолын хөдөлбөргүй нь XIX зуунд байгаль шинжлэлийн арга зүйг нийгэм- хүмүүнлэгийн мэдлэгийн хүрээнд позитивистоор зөөхөд зүй ёсоор оролцсон сонгодог гносеологийн хямралыг илэрхийлсэн байна. Харин аксиологи энэ замд нөгөө л романтик эх сурвалжаас урган гарсан херменевтиктэй тааралдаж, Дильтейн боловсруулсан ойлгохуй-интерпретаци-үнэлгээний онолд тусгалаа олжээ. Энэ мэтчилэн үнэлэмжийн онол философийн ухааны орон зайд өөрийн байр сууриа эзэлсээр л байж.

Зарим холбогдох баримт мэдээллийг дурдъя. 1919 онд М.Хайдеггер их сургуулийн нэг лекцэн дээрээ: "Үнэлэмжийн манлайлалд үнэнхүү итгэж үнэмших нь бүх бололцоот нөлөө болон асуудалтай чиглэлүүдийг даван гарах түгээмэл чанартай зүйл болж байна" гээд үнэлэмжийн философийг "орчин үеийн соёлын философи" гэж нэрлэсэн бол 20-30-аад онд францын гарамгай философич Г.Марсель (1889-1973) Ницшегийн араас энэ замаар явж, латвийн философич Л.Чухина (1913-2002)-гийн яг онож тодорхойлсноор "ахуй хийгээд үнэлэмжийн

<sup>11</sup> Мөн тэнд, 17 дахь талд

<sup>12</sup> Мөн тэнд

хоорондох ялгааг арилгаж”, аксиологи ч зөвхөн соёл судлалыг төдийгүй, онтологийг өөрийг нь мэргэж эхэлсэн ажээ. 1930-аад оны эхээр О.Краус “Үнэлэмжийн онол: Түүх ба шүүмж” номынхоо оршилд “Манай үед үнэлэмжийн онолоорх ажлын тоо ер бусаар өслөө” гэж, францын социологич С.Бугле (1870-1940) Парист хэвлүүлэн гаргасан “Үнэлэмжийн тухай социологи, түүхийн лекцүүд” (1922) гэдэг бүтээлдээ “Үнэлэмжийн философи моод боллоо ... Энэ нь уг чухал асуудалд баяр хөөртэй хандах ашиг сонирхлыг гэрчилж байна” гэж бичсэн байх юм.

Социологи сэтгэлгээний сонгодог сэтгэгч М.Вебер (1864-1920) “Үнэлэмж” хэмээх ойлголтыг мэдлэгийн энэ салбарын нэг түлхүүр ойлголт болгож, нийгэмтүүхийн ертөнцийн “дэг журам” бүрт зуршмалбайх ашиг сонирхлын чиглэлийг энэ ойлголтын тусламжтай тодорхойлжээ. Энэ салбарын цаашдын хөгжилд “үнэлэмжийн хандлага” гэдэг ойлголт түүний үйл ажиллагааны байнгын хэрэглээний нэр томъёо болжээ. Германы түүхч, шашны философич, шашны социологич Э.Трельч (1865-1923) “Түүхчлэх үзэл ба асуудлууд” (1922) гэдэг нэрд гарсан ажилдаа түүхэн судалгаа үнэлэмжийн сургаальтай холбогдох харилцаа холбоог тийм асуудлын нэг болгон ялгаж гаргажээ. Г.Лотцегоос эхлэн түүнд илүү ойр дөт байсан Бадены сургуулийн кантч шинэ үзэлтнүүдийг оролцуулан германы аксиологийн салбарт хийгдсэн бүхнийг эргэцүүлэн Э.Трельч амьдралынхаа сүүлийн 10 жилийн турш философи, түүхийн судалгааны хүрээнд түлхүү ажиллаж, “үнэлэмжийн онолын байр сууринд буюу арга зүйн шинэ байр сууринд шилжилт хийгдлээ” гэсэн хэн ч хэлээгүй санааг нотолжээ. Э.Трельч кантч шинэ үзэлтнүүд болон позитивистуудын энэ онолыг эхлүүлэн босгосон туршлагыг нь шүүмжилсэн байна. Тэрээр хүмүүсийг үнэлэмжээр нь нэгтгэж, энэ нь метафизикт зайлшгүй хүргэх, байгалийн, соёлын, шашны гэх мэтээр ерөнхий зарчмыг илрүүлэхийг оролдож, үнэлэмжийн харилцаа субъектийн хувьч чанарт байх ёстойд ач холбогдол өгөөгүйнх нь төлөө шүүмжилсэн байна.

Э.Трельч “... орчин үеийн үнэлэмжийн онол юуны түрүүнд реформд орох

шаардлагатай, түүний төв цэг нь хүний хувьч чанар байх ёстой юм. Ийм тохиолдолд үнэлэмж нь юмст орших уу, субъектод орших уу, эсвэл тэдгээрийн хоорондох харилцаанд орших уу, үнэлэмж нь сэрэл, хүртэхүй, эсвэл төлөв байдал уу, эсвэл субъектив хариу үйлдэл юм уу, оршихуй, эсвэл эс оршихуйн тухай бодомжид үнэлэмж үндэслэсэн үү, үнэлэмж тогтмол зүйл үү, эсвэл түр зуурын уу, харьцангуй юуу, эсвэл объектив юм уу, үнэлэмж мэдрэх сэтгэл хөдлөл, төсөөлөл, эсвэл бүр психик элементээс үүссэн юм уу, үнэлэмж тохиолдлын уу, бие хүнийх үү, эсвэл сверж бие хүнийх үү гэх мэтсийн тухай хоосон маргаан намсана. Тэгвэл үнэлэмж аяндаа өөрийн субъектив чанараар, мөн практик шинж чанараас аливаа хүний, өөрөөр хэлбэл, бүх амьдралыг чиглүүдэгч практик зорилгоос үүдэн гардаг түүний харьцангуй шинж чанараар ойлгомжтой байх болно. Иймээс үнэлэмжийн харьцангуй байдал бол релятивизм, анархи байдал, санамсаргүй, дур зорго биш, цаг хугацаанаас гадуур хэзээ ч тодорхойлогдож байж чадахгүй, универсаль чанартай, байнга хөдөлж буй бөгөөд баримтат хийгээд зүй ёсны зүйлийг байнга бүтээгч харилцан нэвтрэлцлийг тэмдэглэдэг юм”<sup>13</sup> гэсэн байна. Түүний энэхүү санаанууд философийн хойч үеийнхэнд онцгой ач холбогдолтой болжээ.

1. Энэхүү өгүүлэлээс үзвэл үнэлэмжийн тухай философи онолыг боловсруулахад герман сэтгэгчид голлон гавьяа байгуулжээ гэж үзэж болохоор байна. Тухайлбал энд Г.Лотце, В.Дильтей, Ф.Ницше, В.Виндельбанд, Э.Хуссерель, Г.Мюнстерберг, Г.Риккерт, М.Вебер, Э.Трельч, М.Шелер, О.Шпенглер, М.Хайдеггер нарыг нэрлэж болно.
2. Сэтгэгчид үнэлэмжийн тухай философи онолыг XIX-XX зууны заагаар харьцангуй идэвхитэй боловсруулж эхэлсэн нь тэр үеийн байгалийн шинжлэл, ялангуяа физикт гарсан агуу их нээлтүүдтэй цаг хугацааны хувьд давхцаж байгаа байдал харагдаж байна.

<sup>13</sup> М.С.Каган. Философская теория ценности. Санкт-Петербург, ГОО ТК “Петрополис”, 1997. – 19 дэх галд үзнэ үү.

## НОМ ЗҮЙ

1. Ц.Баатартогтох. Монголчуудын үнэлэмжийн судалгааны философийн асуудал. Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. – УБ., 2000.
2. Т.Дорждагва. Монгол хүний тухай үнэлэмжийн асуудалд //“Монголоо монголоор нь удирдахуй” шилдэг илтгэлийн эмхэтгэл. УБ.: Шинэ удирдлагын академи, 2014.
3. Т.Дорждагва. Соёл судлал. Сурах бичиг. Дөтгөөр хэвлэл – УБ.: БИТПРЕСС, 2013.
4. Т.Дорждагва. “Үнэлэмж” хэмээх ойлгол-тонд холбогдох зарим эргэцүүлэл //“Философийн сургалт, судалгаа: өчигдөр, өнөөдөр” МУИС-ийн Философийн салбарын 50 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүд (CD). 2015.10.16.
5. Т.Дорждагва. Үнэлэмжийн тухай ойлголтыг тодорхойлох асуудалд // МУИС, НШУС-ийн эрдэм шинжилгээний бичиг (Философи, шашин судлалын салбар 244 (27) III). -УБ.:МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2005.
6. Т.Дорждагва, Б.Гантөмөр. Үнэлэмжийн философи үүсэх урьдчилсан нөхцлийн тухайд // Philosophy, Religious Studies. Official Journal of the National University of Mongolia. Vol. 18
7. М.С.Каган. Философская теория ценности. Санкт-Петербург, ТОО ТК “Петрополис”, 1997.

## ABSTRACT

The authors of this article concluded that the emergence of philosophical theories about values associated with the intermediate time of 19-20 century. This time generally coincides with the great discoveries in the natural Sciences, especially in physics. Also, the authors made the conclusion that there are mainly German thinkers have made a great merit.